



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат
компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат
бус гишүүнийг томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9,
Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:


1.“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт, Авлигатай тэмцэх газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 05/11041 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Чулуунбаатарын Баянмөнхийг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс томилсугай.

2.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хараат бус гишүүнд, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000013